



ХҮҮХДИЙН НАЙРАЛ ДУУНД ЗОРИУЛСАН БҮТЭЭЛИЙН УРАЛДААНЫ УДИРДАМЖ

Зорилго:

Монгол улсын хөдөлмөрийн баатар, Төрийн шагналт, Ардын жүжигчин Дагвын Лувсаншаравын нэрэмжит хүүхдийн найрал дууны шилдэг хамтлаг шалгаруулах уралдаан жил болгон явагддаг билээ. Энэхүү уралдаанд зориулж урын санг нэмэгдүүлэн баяжлуулах, Хүүхдийн найрал дууны уламжлал, сургалтыг сайжруулах, хөгжүүлэх, дэмжих, хөгжмийн зохиолчид, уран бүтээлчдийн идэвх сонирхолыг өрнүүлэх зорилгоор Монголын хөгжмийн зохиолчид, уран бүтээлчдийн дунд "Хүүхдийн найрал дуунд зориулсан бүтээл"-ийн уралдаан зарлаж байна.

Хугацаа : 2014 оны 06 дугаар сарын 09-нээс 09 дугаар сарын 01

Уралдааныг зохион байгуулах нөхцөл:

Тус уралдаанд боловсрол, нас харгалзахгүй. Найрал дууны уран бүтээл хийх хүсэлтэй уран бүтээлчид оролцох боломжтой.

Уралдаанд тавигдах шаардлага:

- Уралдаанд өөрийн зохиосон найрал дууны шинэ зохиол бүтээлээр оролцоно.
- Уралдаанд оролцох бүтээлүүдийн шүлэг, зохиол нь хүүхдийн нас,бие, сэтгэхүйд тохирсон байна. /бага, дунд, ахлах ангийн сурагчдад зориулагдсан байна./
- Дууны сэдэв, төрөл жанр чөлөөтэй байна.
- Хөгжмийн авъяас мэдрэмж, сонсголыг хөгжүүлэхэд тодорхой хувь нэмэр оруулж чадахуйц бүтээл байна.
- Орчин үеийн хөгжмийн хэллэг, хэлбэр, элемент, арга барилыг оновчтой чөлөөтэй ашиглана.
- Тус уралдаанд оролцох бүтээл нь өмнө нь дуулагдаж, хэвлэгдэж байгаагүй байх

Уралдаанд оролцох бүтээлүүдийн төрөл:

- А капелла /дан найрал дуу/
- Хөгжимтэй найрал дуу /дууны хөгжим нь оркестр, хамтлаг болон бусад хөгжмийн төрөл хэлбэрт бичигдэж болно/ гэсэн 2 төрлөөр оролцоно.

Шалгаруулалтыг зохион байгуулах, дүгнэх:

Уралдаанд оролцогч нь зохиолынхоо шүлэг, аудио бичлэг, нот /клавир, партитур/-ыг 4 хувь авчирж өгнө. Найрал дууны зохиол бүтээл нь мэргэжлийн өндөр түвшинд зохион туурвигдсан байх шаардлагатай. Уралдаанд оролцох уран бүтээлчид найрал дууны зохиолынхоо шүлэг, клавир, партитур, аудио бичлэгийг /sibelius программ/ 2014 оны 09 дугаар сарын 01-ны дотор Нийслэлийн Соёл Урлагийн газарт хүргүүлнэ. Уралдаанд ирсэн бүтээлүүдээс төрөл тус бүр 4 бүтээлийг шалгаруулж шагнаж урамшуулах ба найрал дууны уралдаант наадмын заавал дуулах найрал дуу болгож нийтэд сурталчилна. Шалгарсан бүтээлүүдийн бичлэгийг хийлгэж CD-д бичиж хадгална.

Уралдааныг мэргэжлийн хөгжмийн зохиолч, хормейстер, яруу найрагчид дүгнэнэ. Оролцох уран бүтээлчид мэдүүлгээ 2014 оны 07 дугаар сарын 01-ны дотор www.buyandelger7810@yahoo.com хаягаар болон цаасаар Нийслэлийн Соёл Урлагийн газарт ирүүлнэ үү. Жич: найрал дууны зохиолынхоо шүлэг, клавир, партитур, аудио бичлэгийг өгөхдөө зохиогчийн нэр бичихгүй авчирна.

Уралдааны болзол:

1. А капелла /дан найрал дуу/

1-р байр	1	өргөмжлөл	1 500 000 /нэг сая таван зуун мянган төгрөг/
2-р байр	1	өргөмжлөл	1 000 000 /нэг сая төгрөг/
3-р байр	1	өргөмжлөл	500 000 /таван зуун мянган төгрөг/
Тусгай байр	1	өргөмжлөл	250 000 /хоёр зуун тавин мянган төгрөг/

2. Хөгжимтэй найрал дуу

1-р байр	1	өргөмжлөл	1 500 000 /нэг сая таван зуун мянган төгрөг/
2-р байр	1	өргөмжлөл	1 000 000 /нэг сая төгрөг/
3-р байр	1	өргөмжлөл	500 000 /таван зуун мянган төгрөг/
Тусгай байр	1	өргөмжлөл	250 000 /хоёр зуун тавин мянган төгрөг/

Ерөнхий зохион байгуулагч:

НИЙСЛЭЛИЙН СОЁЛ УРЛАГИЙН ГАЗАР

Хамран зохион байгуулагч:

НАЙРАЛ ДУУНЫ УРАН БҮТЭЭЛЧДИЙН ХОЛБОО
МОНГОЛЫН ХӨГЖМИЙН ЗОХИОЛЧДЫН ХОЛБОО

Дэмжигч байгууллага:

СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ
СОЁЛ УРЛАГ ХӨГЖҮҮЛЭХ САН